

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2009-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2010.03.15

Эрдэнэбулган сум

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт
1	2	3	4
Нэг: Хүн ам нийгмийн зохистой бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилт Гэр бүлийг дэмжин тэтгэх, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, боловсролтой, ажилтай орлоготой байх нөхцөл бүрдүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлсний үндсэн дээр хүний хөгжил, хүн амын өсөлтийг хангах нийгмийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулна.			
1.1 Эрүүл мэндийн бодлого.			
1	1.1.1. Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлж, хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг уртасгана.	1. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилтийн механизмыг төв болон орон нутгийн түвшинд оновчтой болгоно	НЭМ-ийн хөтөлбөрийн уялдаа холбоог сайжруулах, үр дүнг тогтмол хянах үүднээс хөтөлбөрүүдийг 3 багт зохион байгуулан, тайланг хагас бүтэн жилээр хэлэлцэн үр дүнг тооцон ажиллаж байна. НЭМ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал эмнэлгүүдэд төсөвлөгддөггүй байснаас хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангалтгүй байсан. Харин өнгөрөгч оноос эхлэн сумын эмнэлгүүдэд жилд 91627,4 төгрөгийн төсөв тусгагдаж өгснөөр ЗГ-ын 224-р тогтоолын дагуу тэмдэглэлт өдрүүдээр сургалт явуулах, уралдаан тэмцээн, АСТ, АХА хэлбэрээр өргөн зохион байгуулж иргэдийг НЭМ-ийн үйл ажиллагаанд өргөнөөр оролцуулж идэвхийг нэмэгдүүлж байна. НЭМ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Архангай аймгийн ТББ-уудын ТАН сүлжээ, Дэлхийн зөн Монгол, Мерси кор, Глобал сан, Францын Санте Сюд, Флом ТББ-тай байнгын хамтын ажиллагаатай ажиллаж байна. Биелэсэн -100%
		3. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын удирдамжийн дагуу эрүүл хот, дүүрэг, сум баг, ажлын байр сургууль бий болгох үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулж	Үндэсний хэмжээнд хөтөлбөрт суурилсан төсөвлөлтийн аргад нэвтрэх нэгдсэн шийдвэрийг хүлээж байгаа ба хөтөлбөрт суурилсан төсөвлөлтийн аргын сургалтыг 2008 оны намар сумдын эмч, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад

		хэрэгжүүлнэ	<p>зохион байгуулан мэдлэг олгосон болно. Сум бүр ЭМД айл өрх шалгаруулах болзлыг 2003 оноос эхлэн зарлан хагас бүтэн жилээр дүгнэн урамшуулж 2009 оны байдлаар аймгийн хэмжээнд 250 айл өрх *ЭМ-ийг дэмжигч* айл өрх гэрчилгээг гардан аваад байна. ЭМЯ-ны 2009 оны 6 сарын 15-ний өдрийн А/184 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан *ЭМД байгууллага шалгаруулах* болзлыг сумдад хүргүүлэн ажиллаа.</p> <p>Биелэсэн – 100%</p>
2	1.1.4. Амьжиргааны баталгаажих түвшнгээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үнэ төлбөргүй авах эрхийн бичиг олгоно	1. Төлбөрийн чадваргүй амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй авах эрхийн бичиг олгох үр дүнтэй механизмыг судалж шийдвэрлэнэ.	<p>2009 оны 11 сарын байдлаар Архангай аймагт Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг нийт 111 364 хүнд хийж, Тариат, Өндөрүлаан, Эрдэнэбулган сумдад төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг анхан шатны нэгжийн эмнэлгийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 2790 хүн тус үзлэгт хамрагдаж үүнээс 289 үйлчлүүлэгчийг дараагийн шатлалын эмчилгээ оношлогоонд шилжүүлсэн байна. Мөн Дэлхийн зөн ОНХХ-ийн санхүүжилтээр Хүүхэд хөгжил хамгаалал хөтөлбөрт хамрагдсан эмзэг бүлгийн 800 - аад хүүхдийг аймагт нарийн мэргэжлийн үзлэгт хамруулан үүнээс 33 хүүхдийг Улаанбаатар хотод төрөлжсөн нарийн мэргэжлийн үзлэг, оношлогоонд хамруулж эмчлэн эрүүлжүүлэхэд асран хамгаалагчийнх нь хамт ирж буцах унаа, байр, хоол эмчилгээний бүх зардлыг гаргалаа.</p> <p>Хэрэгжих шатанд- 50%</p>
3	1.1.5. Эрүүл мэндийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төрийн оролцоог багасгах зорилгоор хүн амд үзүүлэх эрүүл	1. Эрүүл мэндийн салбарын эрх зүй, санхүүгийн зохицуулалтын механизмыг боловсронгуй болгоно.	<p>Манай ЭМБ-ын нэгж бүрт МХГазар болон Аудитын газраас тодорхой график болон хуулийн хугацаанд хяналт шалгалт хийж түүний үр дүнгийн талаар дүгнэлт санал зөвлөмжүүдийг өгч түүний дагуу өгсөн санал зөвлөмж дүгнэлтийг ажилдаа</p>

	<p>мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад хувийн хэвшлийн мэргэжлийн эмнэлгийн оролцоог дэмжинэ. Энэ зорилтын хүрээнд эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд хувийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, өмчийн хэлбэрийг үл харгалзан эмнэлгүүдийг даатгалын үйлчилгээнд жигд хамруулна</p>	<p>мөрдлөг болгон байнга хамтран ажиллаж байдаг. ЭМСалбарын санхүүжилтийг боловсронгуй болгох, үйл ажиллагааг нь сайжруулах үүднээс ЭМШУИС-ийн эрүүл мэндийн статистик, эдийн засагчийг орон тоогоор авч ажиллуулж байна. ЭМСалбарын 2008 оны санхүүгийн тайланг нэгтгэн хугацаанд нь холбогдох газруудад тайлагнаж, 2009 оны салбарын хэмжээний тодотгол хийгдсэн төсвийн хуваарийг хүлээн авч төсвийн зүйл ангиар, өмнөх оны гүйцэтгэлийг харгалзан хуваарилан нэгжүүдэд хүргүүлсэн. Төсвийн хуваарийг өмнөх төсвийн хуваарьтай харьцуулахад 400.7 сая төгрөг буюу 7 %-иар буурсан нь үндсэн цалин 95.4 сая, түлш халаалт 67.5 сая, тээвэр шатахуун 47.9 сая, томилолт 15.9 сая төгрөөр тус тус буурсан байна. Тайлангийн хугацаанд салбарын хэмжээний нэгдсэн тайланд аудитын хяналтыг хийлгэсэн.</p> <p>Хэрэгжих шатанд-90%</p>	<p>Хувийн хэвшлийн эмнэлгийн ажиллуулж буй орыг 2010 онд ЭМД-ын санхүүжилтэнд хамруулах сонгон шалгаруулалт хийхэд 6 эмнэлгээс 5 нь үндсэн болон өвөрмөц шалгуурт 80-аас дээш хувийн үнэлгээ авч тэнцсэн. Эрүүл мэндийн салбарын төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын түншлэлийг сайжруулан, зарим үзлэг шинжилгээг хувийн эмнэлгийн эмч нартай хамтран хэрэгжүүлэх зорилгоор албан байгууллагын ажиллагсдын үзлэг шинжилгээг хувийн хэвшлийн эмнэлгүүдээр хийлгэж, сумдад Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран хувийн хэвшлийн эмнэлгийн шүдний эмч нарын үзлэг, шүд хийх үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлж байна. 2009 онд 12 суманд 3000 шахам хүүхдийг шүдний урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх үзлэг, эмчилгээнд үнэ төлбөргүй хамрагдсан. Архангай аймгийн Хувийн хэвшлийн эрүүл мэндийн</p>
	<p>2 Эрүүл мэндийн салбарын төрийн байгууллага болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх оновчтой механизмыг бүрдүүлэх</p>		

			<p>байгууллагын /ХХЭМБ/ хөгжлийн 2009-2015 оны дунд хугацааны стратеги боловсруулагдав. Хувийн эмнэлгүүдийн амбулаторийн үзлэгийн хэрэгжилт 24 хувь, урьдчилан сэргийлэх үзлэгийн хэрэгжилт 28 хувьтай байна. Эрүүл мэндийн төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр хувийн эмнэлгээр гүйцэтгүүлэх зорилтууд Архангай аймгийн ЭМС-ын дунд хугацааны хөгжлийн стратегийн баримт бичигт тусгагд аж, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусан хэрэгжиж байна. Мөн Дэлхийн зөн ОНХХ-ийн санхүүжилтээр Хүүхэд хөгжил хамгаалал хөтөлбөрт хамрагдсан эмзэг бүлгийн 800 - аад хүүхдийг аймагт нарийн мэргэжлийн үзлэгт хамруулан үүнээс 33 хүүхдийг Улаанбаатар хотод төрөлжсөн нарийн мэргэжлийн үзлэг, оношлогоонд хамруулж эмчлэн эрүүлжүүлэхэд асран хамгаалагчийнх нь хамт ирж буцах унаа, байр, хоол эмчилгээний бүх зардлыг гаргалаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжих шатанд – 90%</p>
4	1.1.6. Эрүүл мэндийн удирдлага менежмент, эмчилгээний хяналтын тогтолцоог боловсронгуй болгон бэхжүүлнэ.	1. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын /төрөлжсөн мэргэжлийн, аймаг, дүүрэг, сумын болон өрхийн эмнэлгийн/ үйл ажиллагааны стандартыг шинэчилнэ.	<p>Эрүүл мэндийн байгууллагын / өрх,сум,НЭ-ийн / үйл ажиллагааны стандартыг шинэчлэхэд нэгжүүдээс 2 удаа санал авч нэгтгэн ЗГХА ЭМГ –т хүргүүлсэн болно.</p> <p style="text-align: right;">Хэрэгжих шатанд- 90%</p>
5	1.1.7. Хүн ам ялангуяа өсвөр үе залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох арга хэлбэрийг боловсронгуй болгож, хөдөөгийн хүн амд үйлчлэх явуулын эмнэлгийн тогтолцоог бүрдүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх боломжийг	5. Аймаг бүрт 5-6 сумын дунд явуулын амбулаторийн үйлчилгээг бий болгож, тоноглогдсон тээврийн хэрэгслээр хангана.	<p>Ирээдүйн босго өсвөр үеийн төв нь өсвөр үе залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг үе шаттай байнга хийснээр эрсдэлт зан үйлийг нь өөрчилж амьдралын зөв хэв маягт оруулж болзошгүй эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах чадварт сургаж байна. Сургалтыг мэдлэгийн өртөө аргаар олон хүнд богино хугацаанд олон талын мэдээллийг өөрсдийнх нь оролцооны аргаар өгч байна. Энэ сургалтанд сууснаар нийгмийн даатгал, нийгмийн</p>

	бүрдүүлнэ	<p>халамж, иргэний бүртгэл хөдөлмөр эрхлэлт, жендер, гэр бүл төлөвлөлт, эсэн мэнд амаржихуй, эрүүл мэнд ялангуяа нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг нь сайжирч байна. Эрүүл мэндийн газрын хүүхдийн мэргэжилтэн, өсвөр үеийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн, хоолны мэргэжилтэн нар хамтран Тариат сумын залуу эцэг, эхчүүдэд зөв зохистой хооллолт, бага насны хүүхдийн онцлог, өсвөр насныхны онцлог сэдвээр Дэлхийн зөн орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран бүх сумдын 0-5 настай хүүхдийн залуу эцэг, эхчүүдэд хоол тэжээл эрүүл мэндийн боловсролын талаар, өсвөр үеийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн Тариат сумын Мөрөн баг, Өлзийт сумын өсвөр үеийнхэнтэй уулзаж зөвлөгөө өгч харилцан ярилцаж санал бодлоо солилцож зөвлөгөө өглөө. Хашаат сумын “Шинэ залуус” төрийн бус байгууллагын өсвөр үеийн зөвлөлийн гишүүд Ирээдүйн босго өсвөр үеийн эрүүл мэндийн үйл ажиллагаатай танилцаж нэг хоногийн сургалтанд хамрагдлаа. 1, 2, 3, 4-р 11 жилийн сургуулийн сурагчдад эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдээр байнгын сургалтыг хийж хэвшсэн. Сумдын өсвөр үе залуучуудад эрүүл мэндийн холбогдолтой гарын авлага, материал нөхөн үржихүйн эрүүл мэндийн сонин, Үерхэл сонинг тасралтгүй тараан өгч байна. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ эрүүл мэндийн сургалт сурталчилгаанд аймгийн хэмжээнд 2009 онд 150 сая төгрөг төсөвлөгдөж үүний 45 хувь нь нийгмийн эрүүл мэндийн цуврал сургалт, сурталчилгаанд сум орон нутагт зарцуулагдаж, 49 650 гаруй хүнийг хамруулсан байна. Хөдөө орон нутагт эрүүл мэндийн сургалтыг зөвхөн эмнэлгийн ажилчид биш эрүүл мэндийн сайн дурын ажилтнууд хийдэг болж байгаа нь нийгмийн эрүүл мэндийн хүртээмжинд сайнаар</p>
--	-----------	--

		<p>нөлөөлж байна. 2009 оны байдлаар иргэдийн дунд хийсэн эрүүл мэндийн сургалтын байдлыг авч үзвэл сайн дурын идэвхтний хийсэн сургалт 441, эмнэлгийн ажилчдын хийсэн сургалт 795 арга зүйч буюу нийгмийн ажилчдын хийсэн сургалт 191, үе тэнгийн сургагч 131 удаа тус тус хийж энэ сургалтуудад нийт 32771 хүн хамрагдсан байна. МСС-ны материал НҮЭМ сонин 7500 ширхэг бусад сургалтын материал ном, гарын авлага, зурагт хуудас зэрэг 31440, календарь 140 ширхэг тараагдсан байна. Эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгааг чанаржуулах зорилгоор эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн 411, үе тэнгийн сургагч 379, эмнэлгийн ажилчид 342 ыг тус тус эрүүл мэндийн мэдлэг сэргээх ба сургагч багшийн сургалтанд хамрууллаа. Эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгаанд хэвлэл мэдээллийн байгууллагыг хамруулсан байдал : орон нутгийн телевизээр 90 удаагийн нэвтрүүлэг, сурталчилгааны видео нэвтрүүлэг 372 удаа /нэвтрүүлэг явуулдаг сумдууд хамрагдсан болно./ 13 төрлийн сэрэмжлүүлэг- 61 удаа “Архангай амьдрал “сонинд эрүүл мэндийн булангаар 10 удаа мэдээлэл бичиж иргэдэд хүргэсэн. Мэдээлэл сургалт сурталчилгааны материал хүртээмжийн талаар Эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгааг идэвхжүүлэх засгийн газрын 224-р тогтоолын дагуу орон нутаг мэдээлэл сургалт сурталчилгааг янз бүрийн хэлбэрээр зохион байгуулж хэвшлээ. Сум бүр өөрийн сумын онцлогт тохирсон уралдаан тэмцээн, болзолт уралдаан зохион байгуулж ирлээ. Хайрхан, Тариат, Өгийнуур, Булган, Батцэнгэл сумдууд илүү оролцож байна.</p> <p>Сургалтын материалыг төвөөс ирсэн хэвлэмэл материалаас гадна өөрсдийн хүчээр хийж</p>
--	--	--

		<p>ашиглаж ирлээ. Нийт санамж 7720, гарын авлага 1036, Сурталчилгааны самбар 257-г тус тус сургалтанд ашигласан байна. Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, сүрьеэгийн өвчлөл тархалтыг бууруулах үүднээс 65 хоногийн болзолт уралдааныг Дэлхийн зөн ОУБ-ын ОНХХ-ийн газартай хамтран эмнэлгүүдийн дунд зарлан дүгнэхэд Хайрхан сумын эмнэлэг 1-р байр, Ар Мөнхжин өрхийн эмнэлэг 2-р байр, Ихтамир сумын эмнэлэг 3-р байрыг тус тус эзэлсэн. Уг уралдааны хүрээнд эмнэлгүүд иргэд олон нийтийг нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд татан оролцуулахад чиглэсэн олон ажлыг зохион байгуулсан байна. Жнь: Хайрхан сумын эмнэлэг Мөсний баяр, Дэвжээ тэмцээн, зохион бичлэгийн уралдаан зэрэг арга хэмжээг зохион байгуулсан байна. Болзлын дагуу эмнэлгүүд иргэдэд сүрьеэ өвчнөөс сэргийлэх сургалтыг тогтмол хийсэн.</p> <p>Сургуулийн захирал, нийгмийн ажилтангууд, цэцэрлэгийн багш нарт эрүүл мэндийн хичээлийн талаар нэгдсэн сургалтуудын үед цаг авч мэдээлэл хийсэн. Аймгийн төвийн албан газрын захиалгаар 8 удаа албан газар нь очиж захиалсан сэдвээр нь хичээл хийлээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжих шатанд-90%</p>	
		<p>6. Өрх, сумын эмнэлэг бүрийг нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багцад заасан эмнэлгийн тусламж үйлчилгээг хүн амд бүрэн үзүүлэх чадавхитай болгох, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нь түлхүү хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ</p>	<p>Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг нийт 111 364 хүнд хийж, Тариат, Өндөрүлаан, Эрдэнэбулган сумдад төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг анхан шатны нэгжийн эмнэлгийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 2790 хүн тус үзлэгт хамрагдаж үүнээс 289 үйлчлүүлэгчийг дараагийн шатлалын эмчилгээ оношлогоонд шилжүүлсэн байна. НЭМХ-ээс хэрэгжүүлж буй ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын түвшин тогтоох шаталсан судалгаанд Өлзийт, Ихтамир,</p>

		<p>Цахир сумын 6 багийн 285 хүн хамрагдлаа. Мөн халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэлтэнд ашиглаж буй багаж, тоног төхөөрөмжийн хангамжийн өнөөгийн байдлыг үнэлэх” судалгааг 9 сумын эмнэлэг, 5 өрхийн эмнэлэг, сум дундын эмнэлэг 1, аймгийн нэгдсэн эмнэлгийг хамруулан зохион байгуулж “ EPOS Health management” байгууллагад хүргүүлэв. Байгалийн голомтот, шинэ ба сэргэн тархаж буй халдварт өвчний эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ, халдвар хамгааллын дэглэм, дархлаажуулалт сэдвээр Их тамир сумын хүн эмнэлгийн эмч, сувилагч, багийн дарга, эмч, байгаль орчны байцаагч, Тариат, Цэцэрлэг сумын хүн эмнэлгийн эмч, сувилагч, лаборант нарт сургалт хийж гарын авлагаар хангав. Их тамир, Өндөр-Улаан сумын хачигт хазуулсан асуумжтай хүмүүсээс сонгон 20 хүний цусны ийлдэс цуглуулан тус 2 сумын нутаг дэвсгэрийн газрын гадаргуу болон малаас 77, хүний өвчлөлийн голомтоос 96 ширхэг D.nuttalli зүйлийн хачиг цуглуулан БГХӨСҮТөвийн вирусологийн лабораторит хүргүүлэн шинжлүүлэхэд хачигт риккетсиоз 18, хачигт энцефалит 1 тохилдол гарлаа. Мөн эдгээр сумын хүн эмнэлгийн бэлэн байдлыг шалган ард иргэдэд санамж тарааж сурталчилгаа хийв. Боом өвчний дархлаажуулалтыг Хотонт, Өлзийт, Цэнхэр, Хашаат, Эрдэнэбулган, Хоршоолол, Батцэнгэл, Ихтамир, Төвшрүүлэх, Эрдэнэмандал сумдын голомтот нутгийн 1999 хүнд хийж мэдээг хүргүүлсэн. Мөн галзуугийн вакцин эмчилгээг 27 хүнд хийсэн байна.</p> <p>Зонхилон тохиолдох халдварт өвчний болон хүний томуугийн цар тахлын үед үзүүлэх эмнэлгийн бэлэн байдлын чадавхийг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 04 тоот албан даалгавар гаргуулж, төв</p>
--	--	--

			<p>хөдөөгийн эмнэлгүүдийн бэлэн байдлыг хангуулах, чадавхийг сайжруулах талаар харьяалалын засаг даргын тамгын газар түүний харьяа газруудад үүрэг даалгавар хүргүүлэв. А хүрээний /H1N1/ шинэ вирусын халдвараас сэргийлэх тухай Улсын онцгой комисс, ЭМСайдын 03, 05 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Аймгийн засаг даргын 389, 344, 356, 412 тоот захирамж, 06 тоот албан даалгаврыг гарган эрчимжүүлсний үр дүнд аймагт энэ вирусын халдварын тархалт, хүндрэл бага гарч байгаа хэдий ч бүх шатандаа өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хэрэгжүүлж байна. ЭМЯ-наас томуугийн цар тахлын А (H1N1) вирусын халдварын тархалтын үед хэрэглэх эм, хэрэгсэл ариутгалын бодис зэрэг 25010720 мянган төгрөгийн зүйлс, зохиомол амьсгалын аппарат, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, пульс оксиметрийг төв хөдөөгийн эмнэлгүүдэд хуваарилан хүргүүлэв. Мэдээлэл, мэдээ шуурхай болж, иргэдийн урьдчилан сэргийлэх мэдлэг сайжирч, эмнэлгүүдийн тусламжийн чадавхи сайжирснаар H1N1-ийн халдварыг хязгаарлан барьж чадсан.</p> <p style="text-align: right;">Биелэсэн – 100%</p>
		<p>7. Сумын эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг боловсруулан мөрдүүлж, нөхцлийг сайжруулна</p>	<p>Шинэ халдварын чиглэлээр аймгийн Засаг даргын 2009 оны 10-р сарын 19-ны өдрийн 344-р захирамж болон ЭМГ-ын дарга удаа дараагийн тушаал шийдвэрүүд гаргаж эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Төв хөдөөгийн бүх шатлалын эмнэлгүүдэд эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний чадавхийн тогтолцоо бүрдсэн. Улсын болон хувийн бүх шатлалын эмнэлгүүдэд ЭМГ-ын даргын албан тоотор А хүрээний /H1N1 /I шинэ вирусын халдварын тухай аргачилсан зөвлөмж халдваргүйтгэлийн зааварчлага хүргүүлэв.</p> <p>Аймгийн төвийн 32 албан байгууллага аж ахуйн нэгжид энэ халдварын талаар зөвлөмж,</p>

			<p>халдваргүйтгэлийн бодисын хэрэглээний зааварчлага тус тус хүргүүлж, ЭМГ-ийн мэргэжилтнүүдийг томилж ажиллуулав. ЭМГ-ын даргын 77, 78 тоот тушаалаар томуугийн амбулаторит болон эмнэлэгт суурилсан тандалтын нэгжийн бүрэлдхүүнийг томилон харуулдан тандалтын ажлыг эрчимжүүлж байна. Аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг болон өрхийн эмнэлгүүд өндөржүүлсэн бэлэн байдлаар ажиллаж дараах ажлуудыг зохион байгуулан хийж байна.</p> <p>1. Эрдэнэбулган сумын өрхийн эмнэлгүүд ЭМГ-ийн холбогдох мэргэжилтнүүдийг уртасгасан цагаар 22.00 цаг хүртэл ажиллуулж, өрхийн эмнэлэг бүрт сувилахуйн албанаас гэрээр эргэлт хийх эмнэлгийн хяналт тандалтын пост ажиллуулж байна,</p> <p>2. Томуугийн А /H1N1 / шинэ вирусын халдвартай тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай ЭМГ-ийн даргын 76 тоот тушаалаар, шинэ халдварын бэлэн байдлыг хангах, эмнэл зүйн зөвлөгөө өгөх, санхүү төлөвлөлт, эм хангамж, аж ахуй, сургалт суртчилгаа, халдваргүйтгэл хийх ажлын хэсгийн бүрэлдхүүнийг тус тус томилон ажиллаж байна.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сурталчилгааны баг аймгийн төвийн 28 байгууллагын 1428 хүнд, энэ халдвараас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа хийж 2 төрлийн /Албан байгууллага, хүн амд зориулсан/ зөвлөмж зурагт хуудас тараав • Эмнэлзүйн зөвлөгөө өгөх баг аймгийн нийт хүн амд томуу, томуу төст өвчний үеийн эмнэл зүй, урьдчилан сэргийлэлтээр утсаар зөвлөгөө өгөн ажиллаж байна. • Халдваргүйтгэл хийх багаас Эрдэнэбулган сумын сургууль цэцэрлэг
--	--	--	---

			<p>албан байгууллага зэрэг нийт 20 газрыг халдваргүйтгэлд хамруулсан</p> <ul style="list-style-type: none"> • Бэлэн байдлыг хангах ажлын хэсэг цуглан цаашид хийх ажлын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. • ХӨСҮТ-өөс 3 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн баг ирж х/27-х/30 –ны хооронд аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлгүүдэд томуугийн харуулдан тандалтын цэг байгуулан мэргэжлийн заавар зөвлөмж өгч ажиллаа. • Төв хөдөөгийн эмнэлгүүдээс томуугийн мэдээг тусгай маягтын дагуу нэгтгэн авч харьяа ХӨСҮТ-д томуугийн тандалтын нэгжид мэдээлж байна. Улирлын томуу ихсэж байгаатай холбогдуулан ЕБС цэцэрлэгүүдийн ирц, хүлээн авах яаралтай тусламжийн дуудлага хүүхдийн больницын ачаалал зэрэг мэдээлэлүүдийг нэмэлтээр авч анализ хийн ажиллаж байна. <p>Аймгийн төвийн өрхийн болон амбулаторийн эмч нарыг уртасгасан цагаар ажиллуулж өрхийн эмнэлгийг гэрийн үйлчилгээнд шилжүүлж байна. Үзвэр үйлчилгээ, нийтийн цуглааныг хязгаарлах арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа 5 эмийн санг / эм кампани, Хаш, Сүмбэр, Ар-фарм эм ханган нийлүүлэх байгууллагад ЭМГ-ын даргын албан тоот өгч 24 цагийн үйлчилгээнд шилжүүлэн 14-1 сарын эмийн нөөц, ариутгалын бодис, хамгаалалтын маскны нөөцтэй болголоо. Хаш эмийн сан 0-10 хүртэлх насны хүүхдүүдэд эмийн жороор үнэгүй эмээр үйлчлүүлэх арга хэмжээ авч ажиллуулсан. Эмийн сангууд өвчлөлийн үед хэрэглэгдэх эмийн нэр</p>
--	--	--	--

			<p>төрлийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын 323,351 тоот тушаалын дагуу аймгийн төвийн томуугийн хүлээн авах яаралтай тусламжийн тасгуудаас ТТӨ-ний мэдээг өдөр бүр болон 7 хоногоор авч ХӨСҮТ, ЗГХА аймгийн захиргаа, ОБХ бусад холбогдох газруудад мэдээлж байна. Орон нутгийн Тамир телевизээр энэ халдвараас урьдчилан сэргийлэх талаар ард иргэдэд эмчийн зөвлөгөө 2 удаа өгсөн. Архангайн амьдрал сонинд “Шинэ халдвараас сэргийлэх боломж байна” эмчийн зөвлөмж гаргав. Бүх сумдын засаг дарга болон эмч, эх баригч нарт нийт 35 хүнд шинэ халдварын талаар мэдээлэл урьдчилан сэргийлэх талаар зааварчлага өгөв. Аймгийн нэгдсэн болон сумын эрхлэгч эмч нарт А/Н1N1 / шинэ халдварын эмчилгээ , оношлогоо, урьдчилан сэргийлэлтээр 1 өдрийн сургалт зохион байгуулан ЭМЯ-наас хуваарилсан эм, хувцас хэрэгслэлийг тарааж өгөв. Аймгийн төвийн албан байгуулага аж ахуйн нэгжүүд ажилчдынхаа ажиллах нөхцлийг хангах энэ халдвараас сэргийлэх талаар зохиож буй ажлыг МХГ-тай хамтран шалган зааварчлага зөвлөмж өгөв,</p> <p>Монгол Улсын багшийн их Сургуулийн харьяа Архангай аймгийн багшийн коллеж оюутан сурагчид багш ажилчдад нийт 200 –аад хүнд шинэ халдварын талаар зөвлөгөө өгсөн. 20-н айл өрхөд энэ халдвараас хэрхэн сэргийлэх талаар заавар зөвлөмж өгч ажиллалаа. 31 албан байгууллага аж ахуйн нэгж, бүх шатлалын эмнэлгүүд санамж 380 плакат 120, энэ халдвараас сэргийлэх сурталчилгааны CD хувилж тараасан.</p> <p>Биелэсэн – 100%</p>
--	--	--	---

		8. Багийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд багийн бага эмчийг бэлтгэж, унаатай болгоно.	Нийт багийн эмч нарыг мотоциклоор 100 хувь хангасан. Гэвч ашиглалтын хугацаа хэтэрсэн эвдрэл бүхий мотоциклын судалгааг гаргахад 73.6 хувь болсныг шинэчлэх зорилгоор хандаивлагч байгууллагад хандсан болно. Багийн эмчийн хангалт 88 хувь байна. Хэрэгжих шатанд-90%
6	1.1.9. Шинэ болон сэргэж буй халдварт өвчнөөс сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах өнөөгийн тогтолцоог бэхжүүлж, аймаг дүүргийн түвшинд өргөжүүлнэ	1.Шинэ болон сэргэж буй халдварт өвчнийг лабораторийн шинжилгээнд үндэслэн тандах тогтолцоог үндэсний түвшинд бэхжүүлэх арга хэмжээ авна	Шинэ халдварын чиглэлээр аймгийн Засаг даргын 2009 оны 10-р сарын 19-ны өдрийн 344-р захирамж болон ЭМГ-ын дарга удаа дараагийн тушаал шийдвэрүүд гаргаж эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Төв хөдөөгийн бүх шатлалын эмнэлгүүдэд эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний чадавхийн тогтолцоо бүрдсэн. Улсын болон хувийн бүх шатлалын эмнэлгүүдэд ЭМГ-ын даргын албан тоотор А хүрээний /H1N1 /I шинэ вирусын халдварын тухай аргачилсан зөвлөмж халдваргүйтгэлийн зааварчлага хүргүүлэв. Аймгийн төвийн 32 албан байгууллага аж ахуйн нэгжид энэ халдварын талаар зөвлөмж, халдваргүйтгэлийн бодисын хэрэглээний зааварчлага тус тус хүргүүлж, ЭМГ-ийн мэргэжилтнүүдийг томилж ажиллуулав. ЭМГ-ын даргын 77, 78 тоот тушаалаар томуугийн амбулаторит болон эмнэлэгт суурилсан тандалтын нэгжийн бүрэлдхүүнийг томилон харуулдан тандалтын ажлыг эрчимжүүлж байна. Аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг болон өрхийн эмнэлгүүд өндөржүүлсэн бэлэн байдлаар ажиллаж дараах ажлуудыг зохион байгуулан хийж байна. Эрдэнэбулган сумын өрхийн эмнэлгүүд ЭМГ-ийн холбогдох мэргэжилтнүүдийг уртасгасан цагаар 22.00 цаг хүртэл ажиллуулж, өрхийн эмнэлэг бүрт сувилахуйн албанаас гэрээр эргэлт хийх эмнэлгийн хяналт тандалтын пост ажиллуулж байна, Биелэсэн -

		<p>4. “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үнэдсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, шинэчлэн боловсруулна</p>	<p>100%</p> <p>Томуугийн А /H1N1 / шинэ вирусын халдвартай тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай ЭМГ-ийн даргын 76 тоот тушаалаар, шинэ халдварын бэлэн байдлыг хангах, эмнэл зүйн зөвлөгөө өгөх, санхүү төлөвлөлт, эм хангамж, аж ахуй, сургалт суртчилгаа, халдваргүйтгэл хийх ажлын хэсгийн бүрэлдхүүнийг тус тус томилон ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Сурталчилгааны баг аймгийн төвийн 28 байгууллагын 1428 хүнд, энэ халдвараас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа хийж 2 төрлийн /Албан байгууллага, хүн амд зориулсан/ зөвлөмж зурагт хуудас тараав -Эмнэлзүйн зөвлөгөө өгөх баг аймгийн нийт хүн амд томуу, томуу төст өвчний үеийн эмнэл зүй, урьдчилан сэргийлэлтээр утсаар зөвлөгөө өгөн ажиллаж байна. -Халдваргүйтгэл хийх багаас Эрдэнэбулган сумын сургууль цэцэрлэг албан байгууллага зэрэг нийт 20 газрыг халдваргүйтгэлд хамруулсан -Бэлэн байдлыг хангах ажлын хэсэг цуглан цаашид хийх ажлын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. -ХӨСҮТ-өөс 3 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн баг ирж х/27-х/30 –ны хооронд аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлгүүдэд томуугийн харуулдан тандалтын цэг байгуулан мэргэжлийн заавар зөвлөмж өгч ажиллаа. -Төв хөдөөгийн эмнэлгүүдээс томуугийн мэдээг тусгай маягтын дагуу нэгтгэн авч харьяа ХӨСҮТ-д томуугийн тандалтын нэгжид мэдээлж байна. Улирлын томуу ихсэж байгаатай холбогдуулан ЕБС цэцэрлэгүүдийн ирц, хүлээн авах яаралтай тусламжийн дуудлага хүүхдийн больницын ачаалал зэрэг мэдээлэлүүдийг нэмэлтээр авч анализ хийн
--	--	--	---

		<p>ажиллаж байна.</p> <p>Аймгийн төвийн өрхийн болон амбулаторийн эмч нарыг уртасгасан цагаар ажиллуулж өрхийн эмнэлгийг гэрийн үйлчилгээнд шилжүүлж байна. Үзвэр үйлчилгээ, нийтийн цуглааныг хязгаарлах арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа 5 эмийн санг / эм кампани, Хаш, Сүмбэр, Ар-фарм эм ханган нийлүүлэх байгууллагад ЭМГ-ын даргын албан тоот өгч 24 цагийн үйлчилгээнд шилжүүлэн 14-1 сарын эмийн нөөц, ариутгалын бодис, хамгаалалтын маскны нөөцтэй болголоо. Хаш эмийн сан 0-10 хүртэлх насны хүүхдүүдэд эмийн жороор үнэгүй эмээр үйлчлүүлэх арга хэмжээ авч ажиллуулсан. Эмийн сангууд өвчлөлийн үед хэрэглэгдэх эмийн нэр төрлийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын 323,351 тоот тушаалын дагуу аймгийн төвийн томуугийн хүлээн авах яаралтай тусламжийн тасгуудаас ТТӨ-ний мэдээг өдөр бүр болон 7 хоногоор авч ХӨСҮТ, ЗГХА аймгийн захиргаа, ОБХ бусад холбогдох газруудад мэдээлж байна. Орон нутгийн Тамир телевизээр энэ халдвараас урьдчилан сэргийлэх талаар ард иргэдэд эмчийн зөвлөгөө 2 удаа өгсөн. Архангайн амьдрал сонинд “Шинэ халдвараас сэргийлэх боломж байна” эмчийн зөвлөмж гаргав. Бүх сумдын засаг дарга болон эмч, эх баригч нарт нийт 35 хүнд шинэ халдварын талаар мэдээлэл урьдчилан сэргийлэх талаар зааварчлага өгөв. Аймгийн нэгдсэн болон сумын эрхлэгч эмч нарт А/ Н1N1 / шинэ халдварын эмчилгээ , оношлогоо, урьдчилан сэргийлэлтээр 1 өдрийн сургалт зохион байгуулан ЭМЯ-наас хуваарилсан эм, хувцас хэрэгслэлийг тарааж өгөв. Аймгийн төвийн албан байгуулага аж ахуйн нэгжүүд ажилчдынхаа ажиллах нөхцлийг</p>
--	--	---

			хангах энэ халдвараас сэргийлэх талаар зохиож буй ажлыг МХГ-тай хамтран шалган , зааварчлага зөвлөмж өгөв, Монгол Улсын Багшийн Их Сургуулийн харьяа Архангай аймгийн багшийн коллеж оюутан сурагчид багш ажилчдад нийт 200 – аад хүнд шинэ халдварын талаар зөвлөгөө өгсөн. 20-н айл өрхөд энэ халдвараас хэрхэн сэргийлэх талаар заавар зөвлөмж өгч ажиллалаа. 31 албан байгууллага аж ахуйн нэгж, бүх шатлалын эмнэлгүүд санамж 380 плакат 120, энэ халдвараас сэргийлэх сурталчилгааны CD хувилж тараасан. Биелэсэн -100%
7	1.1.11. Хүн амын эрүүл мэндийн мэдээллийн цахим сан байгуулна. Эмнэлгийн цахим сүлжээ, алсын зайн оношлогоо, эмчилгээг өргөжүүлэн, иргэн бүрт эрүүл мэндийн үйлчилгээг шаардлагтай түвшинд үзүүлэх болоцоог хангах зорилгоор анагаах ухааны орчин үеийн ололтод тулгуурласан төрөлжсөн мэргэжлийн төвүүдийг хөгжүүлж, өвчнийг эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх чадавхийг дээшлүүлнэ.	2. Алсын зайн оношлогооны сүлжээг өргөжүүлж, бүх аймгийн Нэгдсэн эмнэлгийг хамруулна	Эрүүл мэндийн салбарын 30 гаруй байгууллагуудаас сар бүрийн 25-нд мэдээг цуглуулж нэгтгэн боловсруулалт хийн, ЭМЯ болон ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг ЭМГ-т цахим хэлбэрээр мэдээлж, улирал бүр эмнэлгүүдэд эргэн мэдээллийг хийж хэвшээд байна. ЭМБ-уудын статистик мэдээ мэдээлэл хариуцсан ажилтнуудыг УБ хотод НЭМХ-д 5 хоног сургалтанд хамруулан, теле медицине нэвтрүүлсэн клиникийн төв I ,II, III-р эмнэлгүүдийн төслийн үйл ажиллагаатай танилцуулсан. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд /эмнэл зүй, параклиник, мэдээллийн/ мэдээ мэдээллийн нэгдсэн сүлжээнд оруулах бэлтгэл ажил хийгдэж, ЭМЯам, Азийн хөгжлийн банкны ЭМСХ-3 төслийн газарт санал төслүүдийг хүргүүлсэн бөгөөд аймгийн нэгдсэн эмнэлэг, ЭМГ-ын дотоод сүлжээнд холбох ажил хийгдэж дуусах шатандаа ороод байна. Хэрэгжих шатанд -70%
8	1.1.13. “Эрүүл эхээс эрүүл хүүхэд” зарчмыг эмнэлгийн тусламж үйлчилгээний бүх шатанд хэрэгжүүлж, эх хүүхдийн өвчлөл эндэгдлийг	2. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх төрөх, хүүхдийн тасгийн тоног төхөөрөмжийг сайжруулж, хэрэгцээг харгалзан шаардлагатай тохиолдолд төрөх газар болон	Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, эндэгдлийг бууруулах зорилтын хүрээнд 2009 оны эмч, мэргэжилтнүүдийг сургах,материаллаг баазыг бэхжүүлэх, шинэ техник технологийг нэвтрүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлж ажиллав. -Хөдөөгийн

	<p>тууштай бууруулна.</p>	<p>хүүхдийн эмнэлгийг шинээр барьж, перинатологийн төв байгуулна</p>	<p>ядуурлыг бууруулах хөтөлбөр, ЭМЯам, Дэлхийн зөн Монгол зэрэг олон улсын байгууллагаас аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт эх нярайн эндэгдлийг бууруулахад нэн шаардлагатай ИВЛ, кардиомонитор, нярайн кювез зэрэг бүгд 18 сая 258 мянган төгрөгийн 11 төрлийн багаж тоног төхөөрөмжөөр хангалаа. -Аймгийн 18 сумаас 14 сум зөөврийн ЭХО аппаратаар хангагдлаа. Ингэснээр урагийн болон ихэсийн байдлыг харж байна. -5 эх баригчийг сургалтанд хамруулж 2 их эмчийг эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр резидент сургаж байна. -НЭ-ийн төрөх тасгийн нярайн эмчийг нярайн эмчийн 6 сарын сургалтанд ЭМГ-ын зардлаар хамруулж мэргэшүүлж сургасан. Мөн зулайн эхо-ны 1 сарын дамжаанд сургаж дадлагажуулсан. -“Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” сэдэвт нэг өдрийн сургалтыг зохион байгуулан нийт 12 сумын эмнэлэг, аймгийн НЭ-ийн төрөх тасгийн эх баригч бага эмч зэрэг 18 хүнийг хамруулсан. -Эх барихын яаралтай тусламжийн семинарт 3 эх баригч, эрхтэн тогтолцооны эмгэгтэй жирэмсэн эхчүүдийг хянах, төрөлт удирдах арга зүй семинарт эх барихын эмч, дотрын ерөнхий мэргэжилтэн, нярайн анхдагч сэхээн амьдруулахын яаралтай тусламж сэдвээр семинар, курст 3 эх баригч тус тус сууж мэдлэгээ дээшлүүлсэн. -Нярайн нэн шаардлагатай тусламж гэсэн 3 өдрийн сургалтанд 15 сумын эмч, эх баригч, төрөх тасгийн 3 эмч, 4 сувилагч хүүхдийн 2 эмч оролцлоо. Сургалтанд оролцсон 18 эмчид нярайд олонтаа тохиолдох өвчнүүдийн оношлогоо эмчилгээ гэсэн 10 сэдэв бүхий хичээлийн диск хувилж өгөгдсөн. -ЭМЯ-наас зохион байгуулагдсан сургалтанд ЭБЕМэргэжилтэн хамрагдан эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн эмч нарт тухай бүрд нь мэдээлэл хийгдсэн.</p>
--	---------------------------	--	--

		<p>-Нярайн сэхээн амьдруулах өрөөнд отсос, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, нярайн даавуу хатаагч, инкубатор, урагийн бүтэлт үүсч буй эсэхийг хянах урагийн зүрхний цохилт хянах доплерийн аппарат, нярайн дулаацуулах ширээ гэсэн аппарат багаж хэрэгслэлээр хангасан. -Сум, Нэгдсэн эмнэлэгт бээлий болон амны хаалтыг нэг удаагийн хэрэглээнд шилжүүлж эхийн даавууг том хүний памперсаар орлуулан нэг удаагийн хэрэглээтэй болсон.</p> <p>-Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн САЭЭ-ний палат хүүхдийн тасагт зүрх судас, амьсгал хянах монитор 2 ширхэг, отсос 2 ш, инкубатор, бие жинлэх кило, дусал тохируулагч инфузомат 2 ш, пульсокиметр зэрэг 5 сая 631 мянган төгрөгийн 10 нэрийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдлаа.</p> <p>-ЭМСайдын А/145 тоот тушаалыг хэрэгжүүлэх үүднээс 0-15 насны хүүхдийн яаралтай тусламж эрэмбэлэн ангилж үзүүлэх тусламжийн талаар 16 цагийн хичээл, хүүхдийн тасгийн эмч ажилчид, сумдын эрхлэгч нарт сургалт хийсэн.</p> <p>-Тусламжийн эрэмбэлж ангилах 5 бүрдэл бүхий цомог хүснэгтээр бүрдсэн 8 ширхэгийг Тариат, Эрдэнэмандал, хүүхдийн тасаг, хүлээн авах зэрэг 5 газарт байрлууллаа.</p> <p>-Хүүхдийн сэхээн амьдруулах яаралтай тусламжийн курст 1 эмч явуулж сургаж мэргэжил дээшлүүлсэн.</p> <p>Үүний дүнд 2009 онд 15 насны хүүхдийн эндэгдэл 5, 0-1 насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдлоор буурч, 0-1 насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 25,9 промилд хүрч өнгөрсөн онтой харьцуулахад 2,7 промил буурсан үр дүнтэй байна.</p> <p>Аймгийн хэмжээнд нийт 2049 эх төрсөн нь өнгөрсөн оноос 59 тохиолдлоор нэмэгдсэн. Амьгүй төрөлт</p>
--	--	---

			<p>өнгөрсөн онтой харьцуулахад 1 тохиолдлоор буурч эхийн эндэгдэл 1 гарсан.</p> <p style="text-align: right;">Биелэсэн</p> <p>– 100%</p>
9	<p>1.1.19. Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх бодлогыг тодорхойлж, удирдлага зохион байгуулалт, судалгаа, шинжилгээ, эдийн засаг, санхүүгийн механизмыг боловсронгуй болгоно.</p>	<p>1.Биеийн тамир спортын талаар төрөөс баримтлах бодлого"-ыг боловсруулж, биеийн тамир спортын эрчимтэйхөгжлийг хангах эрх зүйн удирдлага зохион байгуулалт, санхүүжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.</p>	<p>МУ-ын ЗГ-ын 05-р тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Аймгийн засаг даргын 31-р захирамж, ЭМС-ын 65-р тушаал, батлагдан гарч “Идэвхитэй хөдөлгөөн-эрүүл аж төрөх ёс” уриан дор хүн амыг идэвхитэй хөдөлгөөнд өргөнөөр хамруулах сарын аян явагдлаа. Үүний дагуу ЭМГ-ын даргын 17 тоот тушаал батлагдан гарч тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор сарын аянд хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж орон нутагтаа энэ ажлыг зохион байгууллаа. Орон нутгийн “Архангайн амьдрал” сонинд “Эрүүл аж төрөхөд идэвхитэй хөдөлгөөний ач холбогдол”, “Таргалалт”, “ Чихрийн шижин” гэсэн сэдвээр мэдээлэл нийтлүүлсэн. Мөн “Нийтийн бүжиг-эрүүл мэнд” сэдэвт бүжгийн тэмцээн аймгийн төвийн албан байгууллага а.а.нэгж, ард иргэдийн дунд зохион байгуулсан бөгөөд энэ үйл ажиллагааг тв-ээр сурталчилсан. Жаргалант суманд хойд бүсийн /Эрдэнэмандал, Цэцэрлэг, Батцэнгэл, Хайрхан/ сумуудын хүн эмнэлгүүдийн эмч ажиллагсадын чуулга уулзалт, спортын анхдугаар бага наадам 6 сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Спортын бага наадам нь буухиа, ширээний теннис, гар бөмбөг гэсэн 3 төрлөөр явагдсан. Тэмцээний нийт дүнгээр багаараа Жаргалант сум I байр, Эрдэнэмандал сум II байр, Хайрхан сум III байр, Батцэнгэл сум IV байр, Цэцэрлэг сум V байр эзэллээ. Шилжин явах цом, өргөмжлөлийг Эрдэнэмандал сум авч ирэх онд бага наадмыг уламжлал болгон хийхээр болсон.</p>

			<p>Хэрэгжих шатанд- 40%</p>
		<p>2. Биеийн тамир спортоор хичээллэхийн ач холбогдлыг сурталчлах мэдээлэл, сурталчилгааны ажлыг нэгдмэл байдлаар зохион байгуулах.</p>	<p>Аймгийн төвийн албан байгууллага а.а.н, ард иргэдийн дунд “Нийтийн бүжиг-эрүүл мэнд” сэдэвт нийтийн бүжгийн тэмцээн зохион байгууллаа. Уг тэмцээнд нийт 18 байгууллагын хос бүжигчид 3 төрлийн бүжгийг хийж идэвхитэй оролцлоо. Үүнд: Хас банк. Цагдаагийн хэлтэс, Шүүхийн багууд I байр, Хүүхдийн т.төв, “Тунгалаг тамир” эмнэлэг, Мэдээлэл сүлжээ компанийн багууд II байр, Боловсрол с.г, Төв номын сан, Нэгдсэн эмнэлгийн багууд III байр эзэлж 100.0 төгрөгийн шагнал урамшуулал гардуулав. Мөн тэмцээний үеэр ард иргэдэд хөдөлгөөний ач холбогдлыг сурталчилах, идэвхижүүлэх зорилгоор Н.Э, ЭМГ-ын эмч ажиллагсадын оролцсон 78 хүний бүрэлдэхүүнтэй “Ажлын байрандаа хийх дасгал хөдөлгөөн”-өөр үзүүлэх тогтлолт хийлээ. Нийтийн бүжиг нь нийтийн биеийн тамир, дасгал хөдөлгөөний нэг төрөл бөгөөд хүн амын бүх давхарга хамрагдах боломжтой юм. Иймээс хүн амыг хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, идэвхитэй хөдөлгөөнийг дадал хэвшил болгох, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх зорилгоор албан байгууллага, а.а.нэгж, ард иргэдийн дунд долоо хоног бүрийн пүрэв гаригт 20-22 цагийн хооронд Аймгийн БТСГ-н зааланд нийтийн бүжгийг явуулж улирал бүрийн сүүлчийн сарын сүүлчийн 7 хоногийн пүрэв гаригт нийтийн бүжгийн тэмцээнийг БТСГ-тай хамтран зохион байгуулах удирдамж гаргаад ажиллаж байна. З.Г-ын 05-р тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд БТСГ, Цэргийн штабаас</p>

			<p>аймгийн төвийн албан байгууллага, ард иргэдийн дунд зохион байгуулсан “Мөсний баяр” 4 төрөлт тэмцээнд байгууллага хамт олноороо идэвхитэй оролцохын зэрэгцээ байгууллага хамт олон дотроо “Эрүүл агаар-эрүүл бие” сэдэвт 3 төрөлт тэмцээн зохиож 4 байр эзлүүлж шагнаж урамшуулав. БТСГ-с зохион байгуулсан “Миний удирдагч-эрүүл мэндийн төлөө хамтдаа” I шатны тэмцээнд хамт олноороо идэвхитэй оролцож гар бөмбөгийн баг шалгарч II шатны тэмцээнд өрсөлдөх эрх авсан.</p> <p>Биелэсэн -100%</p>
		3. Нийтийн биеийн тамир спортын байгууллагын барилга байгууламжийн засвар үйлчилгээ ашиглалтыг үе шаттай сайжруулна	<p>Аймгийн биеийн тамир спортын хороонд 1.8 сая төгрөгний үнэ бүхий биеийн тамирын техник хэрэгсэл авсан байна. Өгийнуур сумын сургуулийн спорт залыг шинээр барьж ашиглалтанд оруулсан байна.</p> <p>Хэрэгжих шатанд - 50%</p>
10	1.1.20. БЗДХ, ХДХВ, ДОХ-ын эрсдэлээс урьдчилан сэргийлж, ХДХВ-ийн халдвар, ДОХ-ын тархалтыг өнөөгийн түвшинд тогтоон барих.	3. Хяналт, шинжилгээ судалгааны үр дүн нотолгоог ХДХВ /ДОХ/ бЗДХ-ын эсрэг хариу арга хэмжээ төлөвлөх шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглана	<p>ДОХ өвчинтэй тэмцэх дэд хөтөлбөрийг аймгийн Засаг даргын 1997 оны 327-р захирамжаар батлан хэрэгжүүлж 2002 онд аймгийн ИТХТ-ийн тогтоолоор шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна.</p> <p>Архангай аймагт “100% бэлгэвч хэрэглэх хөтөлбөр” хэрэгжихтэй холбоотой аймгийн Засаг даргын 36 тоот захирамж гарч аймгийн хэмжээний ажлыг зохион байгуулах чиглэл төлөвлөгөө гаргаад хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан бэлгийн замын халдварт өвчний үзлэгийг чанартай зохион байгуулах ажлын хүрээнд жил бүр 4-5 суманд үзлэг шинжилгээг зохион байгуулан ажилладаг. Сүүлийн 5 жилийн байдлаар 15-40 насны нийт 32116 хүнийг үзлэгт, 25917 хүнийг шинжилгээнд хамруулан 3692 өвчлөлийг илрүүлж эмчилгээнд 6 511 015 төгрөгийн эм зарцуулсан.</p>

			<p>ХДХВ БЗДХ-аас урьдчилсан сургалт сурталчил-гааг тогтмол явуулж сүүлийн 5 жилийн байдлаар 16 170 хүнийг хамруулан явуулсан.</p> <p>2009 оны 9-н сарын 15-наас 11-р сарын 15-ны хооронд /ДОХ,БЗДХ –ын харуулдан тандалтыг, улс даяар явуулсан. 100% бэлгэвч хөтөлбөрийн хүрээнд 3 сард ДОХ-ын төвөөс 3 эмч ирж 3 хоног албан газрын дарга, эмнэлгийн эмч нар 30 хүнд, цагдаагийн бие бүрэлдэхүүн 30 хүн, бар рестораны 30 хүн тус бүрт сургалт семинарыг хийлээ.</p> <p>2009 онд 9 сарын 15-аас 11 сарын 15 хүртэл БЗДХ-ын харуулдан тандалт судалгааг багшийн коллежийн эрэгтэй 100, эмэгтэй 100 оюутнаас асуумж судалгаагаар, жирэмсний кабинетын 200 жирэмсэнд цусны шинжилгээ хийж авлаа.</p> <p>БЗДХ-ын кабинетаар үйлчлүүлэгч 15-49 насны 100 эрэгтэйд асуумж цусны шинжилгээ авч судалгааг явуулахад тэмбүү өвчинтэй 23 хүн илэрч эмчилгээнд хавьтлын хамт орлоо. Үүнээс жирэмсэн 9, кабинетаар үйлчлүүлэгч эрэгтэй 14 хүнд илэрсэн. Мөн 10 сард шадар сайдын ивээл дор төвөөс Хадхүү даргатай 10 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 50 хүн оролцсон аймгийн салбар зөвлөлийн сургалт семинар явуулж мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөв. Сургалт сурталчилгааг 2622 хүнд кабинет, FM, узелээр хийлээ.</p> <p>12 сард ДОХ-ын төвөөс орон нутгийн хүсэлтийн дагуу 4 эмч ирж төв хөдөөгийн эмч нарт БЗХӨ-ийг хам шинжээр илрүүлэх оношлох, эмчилгээг мөн сумдын 20, төвийн 5 нийт 25 лаборант нарт 3 хоногийн сургалтыг хийлээ. Энэ үеэр сумдын эмнэлэгт эм тариа оношлуур тарааж өглөө.</p> <p style="text-align: right;">Хэрэгжих</p> <p>шатанд- 90%</p>
1.2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны бодлого			

11	1.2.2. Баг бүрт гэр цэцэрлэг байгуулах, хувилбарт сургалтын төрөл хэлбэрийг олшруулах замаар сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 2012 он гэхэд 70 хувьд хүргэнэ	1. Бага бүрт гэр цэцэрлэг байгуулж хувийн хэвшлийн цэцэрлэг байгуулахыг дэмжин сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ	Чулуутын Халуун-Ус багт 30, Тариатын Мөрөн багт 30 хүүхдэд цэцэрлэгийн салбар бүлэг ажиллуулан сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлж байна. Хэрэгжих шатанд- 30%
		2. Өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг олгоно.	Нийт 29 цэцэрлэгийн хувилбарт болон ердийн бүлгийн 4534 хүүхдэд 1,738,316,0 мянган төгрөгийн зардал олгогдов. Биелэсэн -100%
		4. Цэцэрлэгийн тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.	Хүүхдийн цэцэрлэгүүдэд “Хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх” иж бүрэн үзүүлэн, хувилбарт сургалтын хөтөлбөр номыг бүлгийн тоогоор буюу 186 ширхэг, дүрслэх урлагийн иж бүрэн үзүүлэнг 30 ширхэгийг олгов. Шинэ барилга ашиглалтанд орж нөхцөл сайжирсан Эрдэнэмандал, Батцэнгэл, Булган сумын цэцэрлэгт тус бүр I, II хоолны тогоо, хувцасны шкаф-80, ширээ сандал-405, цахилгаан пийшин, махны машин, будаа агшаагч, эмнэлгийн булан-2, тоглоомын тавиур-12, гал тогооны шүүгээ, сургалтын хэрэглэгдэхүүний шүүгээ-10 зэрэг 13 төрлийн 530 ширхэг 40,798,271 төгрөгний өртөг бүхий зүйлийг нийлүүлэв Биелэсэн -100%
		5. Цэцэрлэгийн барилга барих, өргөтгөх, засварлах замаар хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	50 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга Батцэнгэл, Цэцэрлэг суманд шинээр, 100 ортой хүүхдийн цэцэрлэг Эрдэнэбулган суманд шинээр барьж байна. Ингэснээр цэцэрлэгийн хүчин чадал 100 ороор нэмэгдэнэ. Биелэсэн -100%

